



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

IX.32. “ХЭЛЭЛЦСЭН нь:

Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн авлагад тооцож хөрөнгө хүлээн авах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь;

Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн А-96 дугаар тушаалаар “Капитал банк” ХХК-ийг албадан татан буулгахаар шийдвэрлэж мөн өдрийн тушаалаар Банкны эрх хүлээн авагч томилж, Эрх хүлээн авагч нь банкны хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, хамгаалах, худалдан борлуулах, иргэд болон төрд учирсан хохирлыг барагдуулахаар ажиллаж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан) Капитал банк (татан буугдсан)-нд байршуулан хадгалж байсан 3,943,155,874.30 (гурван тэрбум есөн зуун дөчин гурван сая нэг зуун тавин таван мянга найман зуун далан дөрвөн төгрөг гучин мөнгө) төгрөгийг гаргуулахаар Банкны тухай хуулийн 71.2.3-д заасны дагуу банкны Эрх хүлээн авагчид хандан нэхэмжлэл гаргаж, авлагыг баталгаажуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 2.8-д зааснаар “Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Банкны эрх хүлээн авагч нартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, татан буугдсан банкны чанаргүй активыг шуурхай барагдуулах, төлбөрт хураагдсан үл хөдлөх эд хөрөнгө болон улсын орлогод хураагдсан эд хөрөнгөөс олсон орлогыг эдийн засгийн эрэлтэд оруулж, эмнэлэг, сургууль, улсын хэрэгцээнд ашиглах” талаар шуурхай арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан.

Энэ ажлын хүрээнд Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн зүгээс үл хөдлөх хөрөнгийг Капитал банкнаас төлөх өр төлбөрийн зарим хэсэгт тооцож, шилжүүлэн өгөх тухай саналыг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж тус газраас зарим хөрөнгийг хүлээн авах асуудлыг дэмжиж хүсэлтээ ирүүлсэн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Капитал банкин дахь мөнгөн хадгаламжийн авлагын зарим хэсэгт тооцож тус Банкны эрх хүлээн авагчаас санал

132002362

9-r huraldaan.docx

болгосон үл хөдлөх хөрөнгийг хоёр тал тохиролцсоны үндсэн дээр шилжүүлэн авч, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан)-ын эргэлтийн хөрөнгийн "худалдан борлуулах зориулалттай үндсэн хөрөнгө" дансанд бүртгэж, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, орлогыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх нь зүйтэй" гэж үзэв.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

